



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/33

Бат-Өлзий сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын "Журам батлах тухай" 2021 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 103 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих Иргэдэд төрийн үйлчилгээг багцаар нь хүргэх боломжийг бүрдүүлэх стандартад нийцсэн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Орбиш (Нийгмийн ажилтан)

Н.Гэрэлмаа (Иргэний төлөөлөл)

Р.Гэрэлт-Од (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Дашдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

